



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/209

Булган сум

**Хэвлэл мэдээллийн ажилтны зөвлөгөөнийг
зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Хэвлэл мэдээллийн ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба (Т.Хонгорзул)-д даалгасугай.

2.Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн Булган аймгийн салбар зөвлөлийн дэргэдэх “Өсвөрийн сэтгүүлчдийн клуб”-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсүгэй.

3.Дээрх арга хэмжээнүүдийн зардалд шаардагдах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
04 дугаар сарын 02-ны/ний өдрийн А/20 дүгээр
захирамжийн хавсралт

Арга хэмжээний зардал

Д/д	Арга хэмжээ	Тоо	Үнэ
1	2	3	4
1	Хоолны зардал	40	1.300.000
2	Цайны завсарлага	20	200.000
3	“Өсвөрийн сэтгүүлчдийн клуб” дэмжлэг	1	500.000
	Нийт		2.000.000